УВС АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТ

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/163/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2026 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ч.Мөнхтогтох<br>Утас: 99454700, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

3.5.1 Төсвийн төлөвлөлт

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

3.5.3 Нэмэлт төсөв

**4. АУДИТЫН ТАЙЛАН**

4.1 Ерөнхий зүйл

4.2 Материаллаг байдал

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026.02.24 № 123
танай ______ -ны № ______ -т

ТЭС СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.ОЮУНЧИМЭГ
ТАНАА

Аудитын тайлан хүргүүлэх
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу танай байгууллагын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, санал дүгнэлтийг хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”, 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасан байдаг.

Иймд аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлж хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт: ... хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 525010041

8525050510

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026.02.24 № УВА-2026/163/НА/СТА-ТШЗ
танай ______________-ны №________________-т

ТЭС СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.ОЮУНЧИМЭГ
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Тэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

8525050223

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **533,762,058.30** | **396,827,983.86** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 371,944,482.72 | 184,207,629.32 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 371,944,482.72 | 184,207,629.32 |
| **3121** | **Төгрөг** | 371,944,482.72 | 184,207,629.32 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 371,944,482.72 | 184,207,629.32 |
| **33** | **АВЛАГА** | 692,006.16 | 11,742,838.02 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 692,006.16 | 11,742,838.02 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 161,125,569.42 | 200,877,516.52 |
| **351** | **Түүхий эд материал** | 196,344.00 | 135,000.00 |
| 35130 | Эм боох материал | 196,344.00 | 135,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 160,929,225.42 | 200,742,516.52 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,422,400.00 | 5,375,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 62,636,139.42 | 65,836,284.42 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,930,000.00 | 170,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 20,508,564.00 | 34,850,964.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 73,432,122.00 | 94,509,368.10 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **9,863,016,860.60** | **9,646,890,859.86** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 9,863,016,860.60 | 9,646,890,859.86 |
| **392** | **Биет хөрөнгө** | 9,783,028,460.60 | 9,566,902,459.86 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 10,194,642,289.00 | 10,194,642,289.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -826,681,071.60 | -1,084,703,304.96 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 712,240,735.50 | 820,724,427.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -425,562,740.50 | -506,962,505.16 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 196,246,137.25 | 229,158,137.25 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -140,253,374.93 | -165,941,428.21 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 107,899,446.93 | 127,332,102.93 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -80,178,181.17 | -92,462,478.61 |
| 39217 | Ном | 44,675,220.12 | 45,115,220.12 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 79,988,400.00 | 79,988,400.00 |
| 39301 | Програм хангамж | 1,040,000.00 | 1,040,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,040,000.00 | -1,040,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 79,988,400.00 | 79,988,400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **10,396,778,918.90** | **10,043,718,843.72** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **72,866,181.00** | **10,411,404.34** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 72,866,181.00 | 10,411,404.34 |
| **413** | **Өглөг** | 72,866,181.00 | 10,411,404.34 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 11,448,167.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 61,418,014.00 | 10,411,404.34 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 61,319,804.00 | 10,411,404.34 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 98,210.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **10,323,912,737.90** | **10,033,307,439.38** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 10,323,912,737.90 | 10,033,307,439.38 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,146,970,167.30 | 1,146,970,167.30 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,146,970,167.30 | 1,146,970,167.30 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 7,255,345,274.28 | 6,964,739,975.76 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7,255,345,274.28 | 7,255,345,274.28 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -290,605,298.52 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,921,597,296.32 | 1,921,597,296.32 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **10,396,778,918.90** | **10,043,718,843.72** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,490,516,752.40** | **5,101,899,594.10** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **15,711,152.40** | **143,393,594.10** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 15,711,152.40 | 143,393,594.10 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,474,805,600.00** | **4,958,506,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,890,918,500.00 | 4,485,745,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,890,918,500.00 | 4,485,745,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 583,887,100.00 | 472,760,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 583,887,100.00 | 472,760,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,817,427,569.76** | **5,392,504,892.62** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,817,427,569.76** | **5,392,504,892.62** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,715,007,890.33 | 5,255,565,792.62 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,829,543,714.00 | 3,376,121,626.33 |
| 210101 | Үндсэн цалин | 1,692,991,736.00 | 1,814,333,183.18 |
| 210102 | Нэмэгдэл | 936,399,031.00 | 1,225,547,144.15 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 90,795,059.00 |
| 210104 | Урамшуулал | 200,152,947.00 | 245,446,240.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 347,345,411.98 | 412,226,968.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 230,034,211.98 | 283,227,868.14 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 29,312,100.00 | 32,332,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,656,000.00 | 16,160,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,718,800.00 | 16,160,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 58,624,300.00 | 64,344,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 594,703,244.57 | 468,386,500.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,154,756.92 | 41,076,805.04 |
| 210302 | Түлш, халаалт | 569,548,487.65 | 419,744,575.30 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 7,565,120.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 81,948,067.00 | 29,867,140.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,073,640.00 | 18,929,050.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,454,000.00 | 8,162,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,800,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 54,620,427.00 | 2,776,090.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 387,488,226.00 | 512,368,964.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,422,946.00 | 1,690,644.00 |
| 210502 | Хоол, хүнс | 384,065,280.00 | 510,678,320.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,002,000.00 | 1,710,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,002,000.00 | 1,710,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 36,515,249.16 | 35,461,090.07 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,529,210.40 | 572,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 403,200.00 | 806,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 40,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 21,542,838.76 | 34,082,690.07 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 432,461,977.62 | 419,423,503.74 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 71,693,850.00 | 21,525,655.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 24,532,900.00 | 20,503,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 336,235,227.62 | 377,394,348.74 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 102,419,679.43 | 136,939,100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 102,410,220.00 | 136,920,100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 79,869,220.00 | 124,830,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 22,541,000.00 | 12,090,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 9,459.43 | 19,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,459.43 | 19,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-326,910,817.36** | **-290,605,298.52** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-326,910,817.36** | **-290,605,298.52** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,807,592,400.00** | **4,958,506,000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,807,592,400.00** | **4,958,506,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,223,705,300.00 | 4,485,745,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,223,705,300.00 | 4,485,745,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 583,887,100.00 | 472,760,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 583,887,100.00 | 472,760,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,336,937,931.59** | **5,060,142,853.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,336,937,931.59** | **5,060,142,853.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,312,333,881.59** | **4,918,592,753.40** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,659,383,020.12 | 3,386,251,833.33 |
| 210101 | Үндсэн цалин | 1,102,338,581.00 | 1,824,463,390.18 |
| 210102 | Нэмэгдэл | 450,081,271.00 | 1,225,547,144.15 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 90,795,059.00 |
| 210104 | Урамшуулал | 106,963,168.12 | 245,446,240.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 184,589,140.00 | 423,277,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 124,245,000.00 | 294,278,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,087,000.00 | 32,332,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,542,000.00 | 16,160,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,542,000.00 | 16,160,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 30,173,140.00 | 64,344,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 315,420,471.17 | 470,060,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,539,071.17 | 33,550,920.70 |
| 210302 | Түлш, халаалт | 301,766,500.00 | 423,264,379.30 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,114,900.00 | 13,244,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 109,266,550.00 | 520,409,720.00 |
| 210502 | Хоол, хүнс | 109,266,550.00 | 520,409,720.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,999,500.00 | 2,681,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,999,500.00 | 2,681,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,693,870.30 | 38,186,590.07 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 12,693,870.30 | 38,186,590.07 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 27,981,330.00 | 77,725,610.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,649,530.00 | 60,060,010.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,331,800.00 | 17,665,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **24,604,050.00** | **141,550,100.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 24,604,050.00 | 141,531,100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,604,050.00 | 129,441,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 12,090,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 19,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 19,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **470,654,468.41** | **-101,636,853.40** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **40,000,000.00** | **86,100,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **40,000,000.00** | **86,100,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 40,000,000.00 | 86,100,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 40,000,000.00 | 86,100,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-40,000,000.00** | **-86,100,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 430,654,468.41 | -187,736,853.40 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 328,420,053.88 | 371,944,482.72 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 759,074,522.29 | 184,207,629.32 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 1,146,970,167.30 | 1,921,597,296.32 | 7,582,046,091.64 | 00.00 | 10,650,613,555.26 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,146,970,167.30** | **1,921,597,296.32** | **7,582,046,091.64** | **00.00** | 10,650,613,555.26 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -326,910,817.36 | 00.00 | -326,910,817.36 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,146,970,167.30** | **1,921,597,296.32** | **7,255,345,274.28** | **00.00** | 10,323,912,737.90 |
| D01 | **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **1,146,970,167.30** | **1,921,597,296.32** | **7,255,345,274.28** | **00.00** | 10,323,912,737.90 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,146,970,167.30** | **1,921,597,296.32** | **7,255,345,274.28** | **00.00** | 10,323,912,737.90 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -290,605,298.52 | 00.00 | -290,605,298.52 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,146,970,167.30** | **1,921,597,296.32** | **6,964,739,975.76** | **00.00** | 10,033,307,439.38 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /улсын төсөв/

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | Зөрүү | хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 4,999,693,400.00 | 4,673,482,653.40 | 326,210,746.6 | 93.5 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 4,999,693,400.00 | 4,673,482,653.40 | 326,210,746.6 | 93.5 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,872,327,500.00 | 4,531,951,553.40 | 340,375,946.6 | 93.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,686,695,400.00 | 3,386,251,833.33 | 300,443,566.7 | 91.9 |
| 210101 | Үндсэн цалин | 2,256,834,000.00 | 1,824,463,390.18 | 432,370,609.8 | 80.8 |
| 210102 | Нэмэгдэл | 1,276,621,800.00 | 1,225,547,144.15 | 51,074,655.8 | 96.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 90,795,059.00 | -90,795,059.0 | 0.0 |
| 210104 | Урамшуулал | 153,239,600.00 | 245,446,240.00 | -92,206,640.0 | 160.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 460,837,100.00 | 423,277,800.00 | 37,559,300.0 | 91.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 313,369,200.00 | 294,278,700.00 | 19,090,500.0 | 93.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 36,867,000.00 | 32,332,400.00 | 4,534,600.0 | 87.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 18,433,500.00 | 16,160,900.00 | 2,272,600.0 | 87.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,433,500.00 | 16,160,900.00 | 2,272,600.0 | 87.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 73,733,900.00 | 64,344,900.00 | 9,389,000.0 | 87.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 527,614,800.00 | 520,409,720.00 | 7,205,080.0 | 98.6 |
| 210502 | Хоол, хүнс | 527,614,800.00 | 520,409,720.00 | 7,205,080.0 | 98.6 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 41,369,500.00 | 38,186,590.07 | 3,182,909.9 | 92.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,600,000.00 | 00.00 | 3,600,000.0 | 0.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 37,769,500.00 | 38,186,590.07 | -417,090.1 | 101.1 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 176,025,200.00 | 163,825,610.00 | 12,199,590.0 | 93.1 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 158,002,800.00 | 146,160,010.00 | 11,842,790.0 | 92.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,022,400.00 | 17,665,600.00 | 356,800.0 | 98.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 146,193,400.00 | 141,531,100.00 | 4,662,300.0 | 96.8 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 146,193,400.00 | 141,531,100.00 | 4,662,300.0 | 96.8 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 134,091,600.00 | 129,441,100.00 | 4,650,500.0 | 96.5 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,101,800.00 | 12,090,000.00 | 11,800.0 | 99.9 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 5,026,387,000.00 | 4,485,745,800.00 | 540,641,200.0 | 89.2 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 4,662,152,400.00 | 4,485,745,800.00 | 176,406,600.0 | 96.2 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 4,485,745,800.00 | 4,485,745,800.00 | 0.0 | 100.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 364,234,600.00 | 00.00 | 364,234,600.0 | 0.0 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 364,234,600.00 | 00.00 | 364,234,600.0 | 0.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 371,944,482.72 | -371,944,482.7 | 0.0 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 184,207,629.32 | -184,207,629.3 | 0.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 01.00 | 01.00 | 0.0 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 04.00 | 04.00 | 0.0 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 70.00 | 68.00 | 2.0 | 97.1 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 44.00 | 44.00 | 0.0 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутгийн төсөв/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 484,841,320.70 | 472,741,200.00 | **12,100,120.70** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 484,841,320.70 | 472,741,200.00 | **12,100,120.70** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 484,841,320.70 | 472,741,200.00 | **12,100,120.70** |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 482,141,320.70 | 470,060,200.00 | **12,081,120.70** |
| Гэрэл, цахилгаан | 35,950,920.70 | 33,550,920.70 | **2,400,000.00** |
| Түлш, халаалт | 430,059,500.00 | 423,264,379.30 | **6,795,120.70** |
| Цэвэр, бохир ус | 16,130,900.00 | 13,244,900.00 | **2,886,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,700,000.00 | 2,681,000.00 | **19,000.00** |
| Урсгал засвар | 2,700,000.00 | 2,681,000.00 | **19,000.00** |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 472,741,200.00 | 472,741,200.00 | - |
| Орон нутгийн төсвөөс | 472,741,200.00 | 472,741,200.00 | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэс сумын Ерөнхий боловсролын сургууль нь Эрүүл чийрэг, амьдрах чадвартай, зөв хандлагатай иргэн төлөвшүүлэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

Тэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тэс сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37,237.6 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 371,944.5 | 184,207.6 | -187,736.9 |
| Авлага | 692.0 | 11,742.812 | 11,050.8 |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 161,125.6 | 200,877.5 | 39,751.9 |
| Үндсэн хөрөнгө | 9,863,016.9 | 9,646,890.9 | -216,126.0 |
| **Нийт хөрөнгө** | **10,396,778.9** | **10,043,718.8** | **-353,060.1** |
| Өр төлбөр | 72,866.2 | 10,411.4 | -62,454.8 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 10,323,912.7 | 10,033,307.4 | -290,605.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **10,396,778.9** | **10,043,718.8** | **-353,060.1** |

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 184,207.6 мянган төгрөг болж 187,736.9 мянган төгрөгөөр буурсан нь санхүүжилт буурч, төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 11,742.5 мянган төгрөг болж 11,050.8 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 200,877.5 мянган төгрөг болж 39,751.9 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй авсан 21,077.2 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд бүртгэсэн, бичиг хэргийн материал, хүнсний материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 10,043,718.8 мянган төгрөг болж 353,060.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн хөрөнгийн элэгдлийн зардал 377,394.3 мянган төгрөг тооцсонтой холбоотой байна. Мөн төсвийн хөрөнгөөр 86,100.0 мянга, хандив болон үнэ төлбөргүй хүлээн авсан 75,168.3 мянган төгрөгийн хөрөнгө данс бүртгэлд тусгасан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 10,411.1 мянган төгрөг болж 62,454.8 төгрөгөөр буурсан нь Монголын цахилгаан холбоо ХХК-нд төлөх wifi төхөөрөмжийн үлдэгдэл 47,148.0 мянган төгрөгийг шилжүүлсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,033,307.4 мянган төгрөг болж 290,605.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,735,985.8 мянга, орон нутгийн төсвөөс 583,887.1 мянга, нийт зарлагыг 5,319,872.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг зардлыг 250,240.0 мянган бууруулж 2025 онд улсын төсвөөс 4,485,745.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 4,485,745.8 мянган төгрөгийн санхүүжилтээс бүрдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,673,482.6 мянган төгрөг буюу 93.5 хувьтай байна. Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 184,207.6 мянган төгрөг байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ерөнхий боловсрол, байр ашиглалт 80226 | 4,149.5 | 4,149.5 | 0.0 | 100% |
| 2 | Ерөнхий боловсрол, хүүхэд хамгаалал 80233 | 4,267.5 | 3,982.5 | 285.0 | 93.3% |
| 3 | Ерөнхий боловсрол, сургалт семинар 80312 | 3,248.9 | 2,416.5 | 832.4 | 74.3% |
| 4 | Ерөнхий боловсрол, эрүүл мэндийг дэмжих 81605 | 4,542.5 | 4,542.0 | 0.0 | 100% |
| 5 | Ерөнхий боловсрол, үдийн цай хөтөлбөр 81801 | 134,091.6 | 129,441.1 | 4,650.5 | 96.3% |
| 6 | Ерөнхий боловсрол, дотоор байрны үйлчилгээ 81806 | 1,620,062.2 | 1,380,981.8 | 239,080.3 | 85,2% |
| 7 | Ерөнхий боловсрол, нөхөн хангалтын зардал 81816 | 85,124.0 | 84,740.0 | 384.0 | 99.5% |
| 8 | Ерөнхий боловсрол, багш ажилтны мэргэжил дээшлүүлэх 81823 | 20,542.9 | 5,935.0 | 14,607.9 | 28.8% |
| 9 | Ерөнхий боловсролын стандарт 81834 | 2,914,677.0 | 2,881,165.5 | 41,541.2 | 98.6% |
| 10 | Ерөнхий боловсрол, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах 81835 | 170,793.1 | 121,934.8 | 48,858.2 | 71.4% |
| 11 | Ерөнхий боловсрол, төрийн өмчийн барилын тогтмол зардал 80111 | 470,060.2 | 470,041.2 | 19.0 | 100% |
| 12 | Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр 81827 | 65,555.6 | 65,438.9 | 116.4 | 99.8% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Тэс сумын Ерөнхий боловсролын сургууль орон нутгийн төсвөөс 472,741.2 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Байр ашиглалттай холбоотой гэрэл цахилгаан 33,550.9 мянга, түлш халаалт 423,264.4 мянга, цэвэр, бохир ус 13,244.9 мянга, урсгал засвар 2,681.0 мянга, нийт 472,741.2 мянган төгрөг зарцуулсан байна.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тэс сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 7 багц дээр тендер зарлаж дотуур байрны хүүхдийн хоолны материалын зардалд 520,409.7 мянган төгрөг, үдийн хоолны материалын зардалд 129,441.1 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Тэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөөгүй болно.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Тэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,817,427.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 48,174.3 мянган төгрөгөөс 80

хувиар тооцож 38,539.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,187,107.5 мянган төгрөгийн 1 хувиар буюу 51,871.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 41,496.8 мянган төгрөгөөр тогтоосон.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тэс сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 134, хугацаа хоцорч оруулсан 35, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

**Аудитын ерөнхий судалгааны дүн**

/мянган төгрөг/

| | Үзүүлэлт | Гүйцэтгэл | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Програм хангамжийн бүртгэл | 1,040.0 | Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн тайлан гаргадаг 1,040.0 мянган төгрөгийг 1 программ байна. |
| 2 | Унаа, хоолны зарцуулалт | 90,795.1 | 2025 онд хоолны хөнгөлөлт 90,795.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. |
| 3 | Сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардал | 1,815.0 | Багшийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалт |
| 4 | Гадаад томилолт, арга хэмжээ | 0 | Зардал гараагүй |
| 5 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал | 0 | Зардал гараагүй |
| 6 | Орон тоо | 3,386,251.8 | Увс аймгийн Тэс сумын Ерөнхий боловсролын сургууль 2025 онд батлагдсан орон тоо 125, гүйцэтгэлээр 114 орон тоотойгоор хичээл сургалтын үйл ажиллагаа явуулж цалин урамшуулалд 3,386,251.8 мянган төгрөг зарцуулсан байна. |

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өгч биелэлтийг Тэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тэс сумын Ерөнхий боловсролын сургууль нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." гэж заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны онцлог, салбарын стандартууд болон хууль, эрх зүйн шаардлагуудад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдсөн эсэхийг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 323,346.3 мянган төгрөгийн 2 алдаа илэрсэнд аудитын явцад 24,221.5 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 299,124.8 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

***Залруулсан алдаа:***

Тэс сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүүгийн үр дүнгийн тайланд бараа үйлчилгээний бусад зардлыг 24,221.5 мянган төгрөгөөр илүү, тээвэр шатахууны зардлыг 18,929.0 мянга, бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлс 2,776.1 мянга, дотоод албан томилолтын зардлыг 1,710.0 мянга, аудит баталгаажуулалт 806.4 мянга, нийт 24,221.5 мянган төгрөгийн зардлыг дутуу илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавар бүртгэнэ, 14.4.6 дахь заалтад "Бүх зардал" гэж заасантай нийцэхгүй, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

## 5.3 Зөвлөмж

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

***Илрүүлэлт:***

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 299,124.8 мянган төгрөгийн зарлагын 35 мөнгөн гүйлгээг хугацаа хоцроосон, байгууллагын хөрөнгийн зарцуулалтай холбоотой төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг байршуулаагүй байна.

***Өгсөн зөвлөмж:***

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үр дүнгийн тайланд гүйцэтгэлээр тайлагнаагүй | 1 | 24,221.5 | | | | | 1 | 24,221.5 | | | | |
| Дүн | 1 | 24,221.5 | | | | | 1 | 24,221.5 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тэс сумын ЕБС | 1 | 299,124.8 | | | | | 1 | 299,124.8 |
| Дүн | **1** | **299,124.8** | | | | | **1** | **299,124.8** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР /Ч.МӨНХТОГТОХ/

2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр